



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 235

Улаанбаатар хот

Г “Шарын гол” ХК-иас “Нако түлш” ХК-ийн Г
хувьцааг сайн дурын үндсэн дээр худалдан
авах санал гаргасныг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11.2, 34.1.8, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”-ын 3.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Шарын гол” ХК-иас “Нако түлш” ХК-ийн олон нийтэд санал болгон гаргасан нийт хувьцааг 100 хувь буюу 12,615,721 ширхэг хувьцааг “Нако түлш” ХК-ийн хувьцаа эзэмшигчдээс сайн дурын үндсэн дээр нэг бүрийг нь 209 /хоёр зуун ес/ төгрөгөөр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2013 оны 6 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. “Шарын гол” ХК-иас “Нако түлш” ХК-ийн хувьцааг сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргаж байгаатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Шарын гол” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захирал /Грам Чапман/-д үүрэг болгосугай:

1/ Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”-ын 6.3, 6.4-т заасны дагуу хувьцааг худалдан авах саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, хувьцааг худалдан авах саналын хугацаа дуусмагц ажлын 10 хоногт багтаан хэрэгжилтийн тайланг Хороонд ирүүлэх;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

000389

3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг мөрдөж ажиллах.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН